

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ:

Судлаач-профессор, Элчин сайд Д.Баярхүү:

Илтгэгч, доктор Д.Базардорж маш тодорхой, оновчтой илтгэл тавилаа. Монгол-Хятадын харилцаан дахь бидний мэдэхгүй олон асуудлыг шинээр гаргаж тавилаа. Хамгийн гол нь энэхүү 1952 оны хэлэлцээрийг Монгол-Хятадын харилцааны түүхэнд хүндтэй байр эзлүүлж, Монгол-Хятадын харилцааны үндсийг тодорхойлсон анхны баримт бичиг гэж түүхэнд оруулаарай гэсэн саналыг тавьж байгаа нь чухал ач холбогдолтой зүйл боллоо гэж үзэж байна. 1960-аад оны дунд үе хүртэл Монгол-Хятадын харилцаа эрчтэй хөгжихөд нөлөөлсөн, хоёр улсын харилцааны үндсийг тодорхойлсон үндсэн гурван тулгуур эрх зүйн баримт бичиг байдаг. Тэдгээр нь 1952 оны энэ хэлэлцээр, 1960 оны «Найрамдал, харилцан туслалцах тухай гэрээ», 1962 оны «Хилийн тухай гэрээ»-нүүд билээ. Энэ жил «Хилийн тухай гэрээ»-ний 60 жилийн ой, анхны тулгуур хэлэлцээрийн 70 жилийн ой тохиож байна.

БНХАУ байгуулагдсаны дараа анх удаа гадаад улсын Засгийн газрын тэргүүн албан ёсны айлчлал хийж, Хятадын үндэсний баярт уригдан оролцож, Хятадын удирдагчдын дунд ганцаараа зогсож байсан түүхэн баримтыг түрүүхэн дэлгэц дээр харууллаа. Хятадын дипломатын түүхэнд анхны гадаадын өндөр дээд хэмжээний зочин гэдгээрээ манай Ерөнхий сайд мөнхөрч чадсан. Мөн Монголын хувьд ч ялгаагүй, Маршал Х.Чойбалсангаас хойш тус орны Ерөнхий сайдаар томилогдсон Ю.Цэдэнбалын гадаадад хийсэн анхны албан ёсны дээд хэмжээний айлчлал БНХАУ-аас эхэлж байжээ. Энэ айлчлал нь Монгол-Хятадын харилцааны тулганы чулууг тавихад түүхэн үүрэг гүйцэтгэсэн. Хоёр улсын харилцааны үндсийг тавилцсан хүн нь Х.Чойбалсангаас гадна Ю.Цэдэнбал байсныг энэ түүх харуулж байна.

1950 онд БНХАУ-ын нийслэлд манай улс ЭСЯ-аа нээж, тухайн үед Элчин сайдаар томилогдсон Баярын Жаргалсайхан, Элчин зөвлөхөөр томилогдсон Сандивын Равдан нарын дурсамжаас үзэхэд тухайн үед манай ЭСЯ, манай дипломатчид Ерөнхий сайд Ю.Цэдэнбал тэргүүтэй төлөөлөгчдийн 1952 оны энэхүү түүхт айлчлал, айлчлалын үед гарын үсэг зурах хэлэлцээрт онц ач холбогдол өгөн ажиллаж байжээ. Мэдээж ЭСЯ-нд бусад олон ажил тулгарч байсан ч улс төрийн үндсэн ажил нь энэ байжээ. Ач холбогдлыг нь ингэж өндрөөр үнэлж, авч үзэж байжээ гэдгийг би зориуд тэмдэглэмээр санагдлаа.

Өөр нэг эгзэгтэй, мартагдсан, дахин судалж үзүүштэй түүх байдаг. Монгол-Хятадын харилцааны түүхэнд хамаарах тул энд хэргээр онцолъё. Хятадтай албан ёсны түвшинд 1946 онд Ерөнхий сайдын орлогч Ч.Сүрэнжав, түүнээс хойш 1952 онд Ерөнхий сайд Ю.Цэдэнбал тус тус айлчилжээ.

1946 онд Ерөнхий сайдын орлогч Ч.Сүрэнжав Чунчин хотод ДИУ-ын Засгийн газартай хэлэлцээ хийж, БНМАУ-ыг ДИУ-аар хүлээн зөвшөөрүүлж,

албан ёсны дипломат харилцаа тогтоосон. 1949 онд ДИУ-ыг халж БНХАУ байгуулагдсан. 1946 онд БНМАУ, ДИУ-ын хооронд дипломат харилцаа тогтоосныг албан ёсоор цуцлаагүйгээр БНМАУ нь БНХАУ-ыг хүлээн зөвшөөрсөн. СССР ба ДИУ-ын хоорондын 1945 оны «Найрамдал, холбооны тухай гэрээ»-г ДИУ 1954 онд цуцалтал СССР ба Монгол нь де-факто оршиж байсан Хятадын хоёр улстай хоёулантай нь дипломат харилцаатай яваад байсан уу гэдгийг олон улсын эрх зүйн үүднээс судалж албан ёсны тайлбар хиймээр санагддаг. Үүнийг манай эрдэмтэд анхааралдаа авна уу.

Өнөөдөр 70 жилийнх нь ойг тэмдэглэж буй 1952 оны энэхүү айлчлал, байгуулсан хэлэлцээр бол БНХАУ-аас тухайн үед гуравдагч ертөнцийн гэгддэг жижиг орнуудтай харилцсан анхны том туршлага байсан болов уу. БНХАУ-ын хувьд Монголтой байгуулсан энэ хэлэлцээр бол хөгжиж буй хил залгаа жижиг улстай байгуулсан анхны эрх тэгш хэлэлцээр байв. Тэр үеийн Хятад бол дэлхийн том гүрэн, 600 сая хүн ам бүхий, гэтэл нэг сая хүрэхгүй хүн амтай жижиг хөрштэйгөө эрх тэгш хамтран ажиллаж болно гэдгийг энэ айлчлал ба хэлэлцээрээр нотолж чадсан. Хэлэлцээрийн “эдийн засаг, соёлын” гэсэн хоёрхон үгэнд л бүх зүйл багтаж байсан. Энэ хэлэлцээр нь хоёр талын хамтын ажиллагааны суурь гэрээг угтуулсан, хоёр талын харилцааны үндсийг тодорхойлсон, 1960 оны гэрээтэй эн зэрэгцэхүйц ач холбогдолтой түүхэн баримт бичиг байжээ гэдгийг тэмдэглэхийг дахинтаа хүсэж байна.

Элчин сайд Г.Батсүх:

Хоёр талын харилцааны түүхийн чухал баримт бичгийн талаар тусгайлан эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулж, урьж оролцуулж байгаад талархлаа илэрхийлье. Доктор Д.Базардорж хэлэлцээрийн талаар маш товч, тодорхой, өнгөрсөн одоо ирээдүй цагийг харсан олон талын дүгнэлттэй илтгэл тавилаа. Энэ «Эдийн засаг ба соёлын хэлэлцээр» бол орчин үеийн хэлээр “булган сүүлтэй” суурь хэлэлцээр байжээ. Хоёр талын засгийн газар аль аль нь шинэ байлаа. Хэлэлцээр байгуулагдсаны дараагаар Ерөнхий сайд Жоу Эньлай хэлэхдээ “БНХАУ байгуулагдсаны дараах анхны гадаад улсын засгийн газартай байгуулж байгаа гэрээ боллоо” гэсэн бол Ерөнхий сайд Ю.Цэдэнбал “Найрамдал, энх тайвны үзэл санаа нэвт шингэсэн, эрх тэгш зарчим дээр байгуулагдсан, Монгол-Хятадын харилцааны тэр цагийн болоод ирээдүйн суурь, шинэ хуудас боллоо” хэмээн тэмдэглэсэн байдаг.

Энэхүү хэлэлцээр байгуулагдсанаас жилийн дараа буюу 1953 онд хамгийн анхны Худалдааны хэлэлцээр байгуулах эхлэл тавигдсан. Хоёр орны бараа гүйлгээ, төлбөрийн хэлэлцээрийг байгуулж, үүн дээр үндэслэн Засгийн газар хоорондын баримт бичгийн дагуу хоёр талын худалдаа явагдаж эхэлсэн түүхтэй. Тэр үед Монгол улсын экспорт хязгаарлагдмал байсан ч Хятад улсад 20 мянган адуу нийлүүлсэн, 10 жилийн дараа буюу 1962 онд 80 мянган адуу нийлүүлээд, хоёр улсын худалдаа тасарсан байдаг.

Бидний мэдэж байгаагаар хоёр талын харилцаанд сүүдэр унагасан хүйтэн дайны үе, ЗХУ-БНХАУ-ын харилцаанд тохиосон хүнд хэцүү нөхцөл байдал Монгол-Хятадын харилцаа, худалдаанд ч нөлөөлсөн. Хамтын ажиллагаа тэр тусмаа, шинжлэх ухаан, техникийн тусламж, эдийн засгийн тусламж, зээл тусламжаар хэрэгжиж байсан томоохон төслүүд, олон мянган хятад ажилчид, мэргэжилтнүүдийн хийж байсан бүтээн байгуулалтын ажлууд тасарч байсан түүхтэй. Гэхдээ Д.Базардорж докторын хэлсэнчлэн энэ анхны том, суурь гэрээ маань өнөөдөр хүртэл амьтай байж өнөөдрийн иж бүрэн стратегийн түншлэлийн харилцааны ноён нуруу, суурь болсоор байна. Харамсалтай нь мартагдах дөхсөн байна, бид мартаж өсгүй гэж дүгнэжээ. Энэ хурлаар Монгол-Хятадын харилцааны түүхэн санамжийг гаргаж ирлээ. 1 жил, 10 жилийн ойг нь тэмдэглэж байсан байна. Хоёр талын харилцааны "Алтан арван жил"-д ЗХУ-БНМАУ-ын харилцаа гурван улсын харилцааг тэнцвэржүүлэхэд ач холбогдолтой байжээ гэдгийг бодож байх хэрэгтэй. Өнөөдрийн түвшинд 10 тэрбум долларын худалдаа хийсэн байна гэхдээ төмөр зам, тээврийн асуудал байсаар байгааг бид санах хэрэгтэй. 1953 онд байгуулсан төмөр замын гурван талын гэрээний хэрэгжилт нь зогссон, хатуу сургамж өгсөн. Хоёр талын харилцаа бүх төрлийн салбарт түүний дотор худалдаа, эдийн засгийн салбарт эрчимжиж байгаад гадаад худалдааны салбарын хүний хувьд туйлын баяртай байдгаа хэлье.

Доктор, профессор Д.Уламбаяр:

Өнөөдрийн энэхүү эрдэм шинжилгээний хуралд урьж оролцуулж байгаа ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн удирдлагад талархлаа илэрхийлье. Д.Базардорж докторын илтгэлд хэд хэдэн чухал санаа гарлаа. *Нэгдүгээрт*, 1952 оны 10 дугаар сарын 4-нд Бээжин хотноо гарын үсэг зурсан «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр» нь хоёр орны харилцааны үндсэн суурь, анхны эрх зүйн баримт бичиг байсан гэж дүгнэжээ. *Хоёрдугаарт*, 1960 оны 5 дугаар сард Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан «БНМАУ, БНХАУ хоорондын Найрамдал, хамтын ажиллагааны гэрээ»-ний гол үндэс суурь болсон гэсэн чухал дүгнэлтийг хийжээ. *Гуравдугаарт*, 1962 онд 1952 оны хэлэлцээрийн 10 жилийн ойг нь өндөр дээд түвшинд тэмдэглэж байсан байна, өнөөдөр бид сайх хэлэлцээрийн 70 жилийн ойг нь тэмдэглэж байна. Энэхүү хэлэлцээр дээр үндэслэсэн 1950-иад оны хоёр орны харилцааг "Алтан 10 жил" гэж тэмдэглэхээс өөр аргагүй юм. Дараагийн нэг чухал зүйл бол энэ хэлэлцээрийг байгуулахад маршал Х.Чойбалсан онцгой анхаарч ажиллаж байсантай холбогдуулан 1951 оны баримтыг хөндөж байна.

Монгол Улс хоёр хөрштэйгөө тэнцвэртэй харьцах бодлогыг Гадаад бодлогын үзэл баримтлал, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалдаа оруулсан байдаг. Тухайн үед Зөвлөлтийн талыг баримталсан чиг хандлагыг

тэнцвэржүүлэхэд дурдсан хэлэлцээр зохих хувь нэмрээ оруулсан гэсэн санааг гаргасан нь ихээхэн анхаарал татаж байна.

Би нэг зүйлийг нэмж дурдахад, 1952 оны 10 дугаар сарын 4-нд Бээжин хотноо «БНМАУ, БНХАУ-ын хоорондын эдийн засаг ба соёлын хамтын ажиллагааны тухай хэлэлцээр»-т гарын үсэг зурахын өмнөхөн буюу 1952 оны 9 дүгээр сарын 15-нд Москва хотноо БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, БНХАУ-ын Төрийн Зөвлөлийн Ерөнхий сайд бөгөөд ГЯЯ-ны сайд Жоу Эньлай, ЗСБНХУ-ын СнЗ-ийн Нэгдүгээр орлогч дарга бөгөөд ГЯЯ-ны сайд А.Я.Вышинский тэргүүтэй гурван хөрш орны Засгийн газрын тэргүүн нарын өндөр дээд түвшний уулзалт зохион байгуулагдсан. Тус уулзалтад ЗХУ-ын удирдагч маршал И.Сталин байлцсан юм. Москвагийн энэхүү уулзалт гурван хөршийн удирдагчдын хамгийн анхны өндөр дээд түвшний уулзалт байсныг тэмдэглэмээр байна.

Энэ уулзалтаар гурван хөрш улсыг босоо тэнхлэгийн төмөр замаар холбох асуудлыг хөндсөн байдаг. Уг уулзалтын үр дүнд 1949 онд ашиглалтад орсон Наушка-Улаанбаатарын төмөр замыг үргэлжлүүлж, Улаанбаатар – Замын-Үүд – Жининий хооронд төмөр зам барихаар тохиролцож, удалгүй бүтээн байгуулалтын ажил амжилттай өрнөж эхэлжээ. 1955 оны 12 дугаар сарын 31-нд Улаанбаатар – Замын-Үүдийн төмөр замыг нээх ёслолын үйл ажиллагаа Улаанбаатарт болж, 1956 оны 1 дүгээр сарын 1-нээс ЗСБНХУ, БНМАУ, БНХАУ-ын хооронд төмөр замын шууд харилцаа нээсэн тухай дэлхийн улс орнуудад зарлан тунхагласан. 1956 оны 1 дүгээр сарын 3-нд Монгол, Хятадын хил дээр сайх төмөр замыг холбох мөнгөн хадаасыг хадах ёслолын ажиллагаа болж, БНМАУ-ын Ерөнхий сайд Ю.Цэдэнбал, ЗСБНХУ-ын Зам харилцааны сайд Б.П.Бещев, БНХАУ-ын Зам харилцааны сайд Тэнь Дэюан нар оролцсон байдаг.

Энэ үйл явдал нь 1952 оны 10 дугаар сарын хэлэлцээрт чухал нөлөө үзүүлсэн юм болов уу гэсэн сэтгэгдэл төрлөө. Энэ хэлэлцээр өнөөдрийн Монгол-Хятадын эдийн засаг, соёлын харилцааны 70 жилийн түүхийн эрх зүйн үндэс суурийг тавьжээ гэж дүгнэсэнтэй санал нэг байна. Хоёр улсын харилцааны эрх зүйн үндсийг тавьсан дээрх дурдсан хэлэлцээрийг эрдэм шинжилгээний хурлын хүрээнд тусгайлан өндөр түвшинд хэлэлцэн дүгнэж байгаа нь зарчмын чухал ач холбогдолтой гэж үзэж байна.